



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Үл хөдлөх хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоол, 38 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тахарын ерөнхий газар /хуучнаар/-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан нийт 2,592,303,500.00 (хоёр тэрбум таван зуун ерэн хоёр сая гурван зуун гурван мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 911,977,946.00 (есөн зуун арван нэгэн сая есөн зуун далан долоон мянга есөн зуун дөчин зургаан) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Тагнуулын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Тагнуулын ерөнхий газрын дарга, хурандаа Д.Гэрэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.2.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Үл хөдлөх хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 570 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001390

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 01 дугаар сарын 01 ны өдрийн
 01... дугаар тогтоолын хавсралт



**ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР (ТАТАН БУУГДСАН)-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЙСАН,
 ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Барилга, байгууламжийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Хэм- жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Барилга	1997.01.01	ш	1	2,585,799,500.0	2,585,799,500.0	905,473,946.0	1,680,325,554.0
2	Бохир усны шугам	1997.01.01	ком	1	6,200,000.0	6,200,000.0	6,200,000.0	0.0
3	Бут сөөг	2003.01.01	ш	10	2,800.0	28,000.0	28,000.0	0.0
4	Зүлэгжүүлсэн талбай	2003.01.01	м2	60	4,600.0	276,000.0	276,000.0	0.0
	Нийт дүн					2,592,303,500.0	911,977,946.0	1,680,325,554.0
						(хоёр тэрбум таван зуун ерэн хоёр сая гурван зуун гурван мянга таван зуун)	(есөн зуун арван нэгэн сая есөн зуун далан долоон мянга есөн зуун дөчин зургаан)	(нэг тэрбум зургаан зуун наян сая гурван зуун хорин таван мянга таван зуун тавин дөрвөн)